



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

“Аюулгүй ажиллагааны
эрсдэлийн үнэлгээний баг”-ийн
бүрэлдэхүүнийг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.2, 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэний нисэхийн үндэсний төвийн “Аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. “Аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээний баг”-ийн төлөвлөгөө, Иргэний нисэхийн үндэсний төвийн “Эрсдэлийн гарын авлага”-ыг 2021 оны 4 дүгээр сард багтаан боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласугай.
3. “Аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээний баг”-ийн ажлын тайланг Аюулгүй ажиллагааны зөвлөлийн даргад тайлагнаж ажиллахыг Эрсдэлийн үнэлгээний багийн дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Ж.Зулцэцэг/-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн
А/12 дугаар тушаалын хавсралт



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Эрсдэлийн үнэлгээний
багийн дарга:

Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага,
дотоод хяналтын албаны ахлах мэргэжилтэн
Б.Алтантуяа

Эрсдэлийн үнэлгээний багийн
Нарийн бичгийн дарга:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
албаны Аюулгүй ажиллагааны хэсгийн
мэргэжилтэн Л.Номин

Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага,
дотоод хяналтын албаны аюулгүй
ажиллагааны мэргэжилтэн Ч.Хоролгүр

Эрсдэлийн үнэлгээний багийн
гишүүд

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
албаны Аюулгүй ажиллагааны хэсгийн дарга
Б.Мандухай

Холбоо навигаци, ажиглалтын албаны
Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын
хэсгийн дарга Ч.Чулуунхүү

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын
Үйлдвэрлэл, төлөвлөлт, зохицуулалтын
хэлтсийн дарга Л.Тэгшээ

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны
Аюулгүй ажиллагаа, чанар хангалтын
хэсгийн дарга Д.Эрдэнэбаатар

Нислэгийн журам боловсруулалтын албаны
Захиргаа, дотоод хяналтын хэсгийн дарга
Б.Болор-Эрдэнэ

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун
хангамжийн албаны Аюулгүй ажиллагаа,
дотоод хяналтын тасгийн дарга
Б.Сосорбарам

Оношилгоо хэмжил зүйн лабораторийн
чанарын менежер Н.Бүжинханд

Нисэхийн сургалтын төвийн захирал
Б.Гангэрэл